APU COMPANY
Absolute. Pure. Unique.

# "АПУ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 08 сарын 13 -ны өдөр Дугаар 20/15 Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫГ ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТ ХЭЛБЭРЭЭР ЯВУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйлийг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтын хэлбэрээр (цаашид 'Эчнээ санал хураалт' гэх) явуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Эчнээ санал хураалтаар хэлэлцэх асуудлуудыг нэгдүгээр хавсралтаар, эчнээ санал хураалтын саналын хуудсын загварыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоолыг баталсан тухай мэдэгдлийг 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдөр Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсүгэй.
4. Эчнээ санал хураалт явуулах зар мэдээг Монголын Хөрөнгийн Биржийн болон компанийн цахим хуудсаар нийтэд зарлаж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр дамжуулан 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдөр мэдээлсүгэй (Давталтыг 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр явуулсугай).
5. Эчнээ санал хураалтад оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөр тогтоосугай.
6. Эчнээ санал хураалтаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдөр үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлсүгэй.
7. Эчнээ санал хураалтаар хувьцаа эзэмшигчид саналаа өгөхдөө саналын хуудсыг БиДиСек ҮЦК ХК, өөрийн харилцдаг үнэт цаасны брокер дилерийн компаниар дамжуулан хүлээн авах боломжтой бөгөөд 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн санал авах сүүлчийн хугацаа хүртэл санал өгөх эрхтэй байхыг дурдсугай.
8. Санал авах хуудсаар санал авах сүүлчийн хугацааг 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 16:00 цагт байхаар тогтоосугай.
9. Дараах нэр бүхий хүмүүсийг эчнээ санал хураалт Зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Зохион байгуулах комиссын дарга:

Ч.Ариунсан (ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга)

Зохион байгуулах комиссын гишүүд:

Э.Солонго (ТУЗ-ийн ажлын алба)

Б.Мягмар (ТУЗ-ийн ажлын алба)

10. Дараах нэр бүхий хүмүүсийг Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Тооллогын комиссын дарга:

Б.Онон (БиДиСек ҮЦК ХК)

Тооллогын комиссын гишүүд:

Э.Эрхэмзаяа (БиДиСек ҮЦК ХК)

Б.Түвшинбаяр (БиДиСек ҮЦК ХК)

11. АПУ ХК-ийн бүртгэгдсэн хувьцаа эзэмшигчдэд эчнээ санал хураалт хийх тухай зар мэдээг нийтэд мэдээлсэн өдрөөс эхлэн санал авах сүүлчийн хугацаа хүртэл хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичигтэй БиДиСек ҮЦК ХК болон харилцагч үнэт цаасны компанийн байранд, ажлын цагаар танилцах боломжийг бүрдүүлэхийг Зохион байгуулах комисст даалгасугай.

12. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу эчнээ санал хураалтыг явуулж, зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Зохион байгуулах комисст даалгасугай.

| № | Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн |
|---|---|---|---|---|
| 1 | П.Батсайхан | | | |
| 2 | Б.Батбаяр | | | |
| 3 | Сергей Громов | | | |
| 4 | Кеннет Чу | | | |
| 5 | Я.Дамдинсүрэн | | | |
| 6 | Томас Холланд | | | |
| 7 | Ө.Батбаяр | | | |
| 8 | Ё.Гэрэлчулуун | | | |
| 9 | Ж.Үнэнбат | | | |

10. Дараах нэр бүхий хүмүүсийг Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Тооллогын комиссын дарга:

Б.Онон (БиДиСек ҮЦК ХК)

Тооллогын комиссын гишүүд:

Э.Эрхэмзаяа (БиДиСек ҮЦК ХК)

Б.Түвшинбаяр (БиДиСек ҮЦК ХК)

11. АПУ ХК-ийн бүртгэгдсэн хувьцаа эзэмшигчдэд эчнээ санал хураалт хийх тухай зар мэдээг нийтэд мэдээлсэн өдрөөс эхлэн санал авах сүүлчийн хугацаа хүртэл хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичигтэй БиДиСек ҮЦК ХК болон харилцагч үнэт цаасны компанийн байранд, ажлын цагаар танилцах боломжийг бүрдүүлэхийг Зохион байгуулах комисст даалгасугай.

12. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу эчнээ санал хураалтыг явуулж, зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Зохион байгуулах комисст даалгасугай.

| № | Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн |
|---|---|---|---|---|
| 1 | П.Батсайхан | | | |
| 2 | Б.Батбаяр | | | |
| 3 | Сергей Громов | | | |
| 4 | Кеннет Чу | | | |
| 5 | Я.Дамдинсүрэн | | | |
| 6 | Томас Холланд | | | |
| 7 | Ө.Батбаяр | | | |
| 8 | Ё.Гэрэлчулуун | | | |
| 9 | Ж.Үнэнбат | | | |

УЛААНБААТАР ХОТ "АПУ" ХК-ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТС8896 ☐ 2702673

*Translated from Mongolian*

**APU JSC BOARD OF DIRECTORS RESOLUTION**

Date: 13 August 2020 No 20/15 Ulaanbaatar

**CALL FOR EXTRAORDINARY GENERAL MEETING OF SHAREHOLDERS (VOTING BY CIRCULATION)**

Pursuant to Article 73 of the Company law of Mongolia, it is hereby **RESOLVED to**:

1. Call an Extraordinary General Meeting of Shareholders of APU JSC to be organized in the form of a voting by circulation (the "Circulation Voting");

2. Approve the Circulation Voting agenda as per annex 1 and the voting ballot template as per annex 2 hereto;

3. Notify the Mongolian Stock Exchange and the Financial Regulatory Commission of the adoption of this resolution on 14 August 2020;

4. Publish a notice of the Circulation Voting on both websites of the Mongolian Stock Exchange and APU JSC and announce through the mass media including daily newspapers or nationwide broadcasters (radio or television) on 18 August 2020 (to be re-announced on 02 September 2020);

5. Fix the record date for the Circulation Voting to be 02 September 2020;

6. Deliver the Circulation Voting agenda, draft resolutions, voting ballots and other relevant documents to brokerage and dealing companies on 21 August 2020;

7. Advise that, through BDSec UTsK JSC or their brokerage and dealing companies, shareholders can receive voting ballots and cast their votes from 21 August 2020 to the voting deadline;

8. Set the voting deadline to be 02 October 2020 at 16:00;

9. Appoint the following persons to a Circulation Voting Organizing Committee:

   Head of the Organizing Committee:

   Ch.Ariunsan (Board Secretary)

   Members of the Meeting Organizing Committee:

   E.Solongo (Board Secretariat);

   B.Myagmar (Board Secretariat); and

10. Appoint the following persons to a Tabulation Commission:

   Head of the Tabulation Commission:

   B.Onon (BDSec UTsK JSC)

   Members of the Tabulation Commission:

   E.Erkhemzaya (BDSec UTsK JSC)

   B.Tuvshinbayar (BDSec UTsK JSC)

11. Direct the CEO and the Organizing Committee to provide shareholders with the opportunity to review the documents pertaining to the agenda items at the offices of BDSec UTsK JSC and their brokerage and dealing companies during working hours from the date of public announcement of the Circulation Voting notice to the voting deadline; and

12. Assign the Organizing Committee to conduct the Circulation Voting, disseminate the notice thereof and implement this resolution in accordance with applicable laws and regulations.

| № | Director | Agreed | Disagreed | Abstained |
|---|---|---|---|---|
| 1 | P.Batsaikhan | | | |
| 2 | B.Batbayar | | | |
| 3 | Sergey Gromov | | | |
| 4 | Kenneth Choo | | | |
| 5 | Ya.Damdinsuren | | | |
| 6 | Thomas Holland | | | |
| 7 | U.Batbayar | | | |
| 8 | Yo.Gerelchuluun | | | |
| 9 | J.Unenbat | | | |

АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2020 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн
20/15 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт

**АПУ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТААР ШИЙДВЭРЛЭХ АСУУДАЛ**

1. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох;

2. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд (кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн)-ийг сонгох.

АПУ ХК -ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2020 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн
20/15 тоот тогтоолын хоёрдугаар хавсралт

**АПУ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТААР ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС**
**Хэлэлцэх асуудал №1**

Хувьцаа эзэмшигчийн овог: ............................ Нэр: .......................................

Регистрийн дугаар: ..............................................

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн Тоо: .......................................

Бүртгэсэн /Үнэт цаасны компани/: ................................................................................

Брокерийн овог: .................................... Нэр: .......................................

Энэхүү саналын хуудсаар 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 16:00 цаг хүртэл БиДиСек ҮЦК ХК-ийн байр (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө, 27/1 тоот) болон санал өгөгчийн харилцагч үнэт цаасны компанийн байранд санал өгнө.

**Дараах хэлэлцэх асуудалд ЕРДИЙН АРГААР санал хураана.**
**Саналын хуудас бөглөх заавар**: Ердийн журмаар саналаа өгөхөд тухайн асуудлаар "зөвшөөрсөн", "татгалзсан", "түдгэлзсэн" аль нь болохыг ✓ тэмдэглэж, саналын ард гарын үсгээ зурна.

| № | ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн | Татгалзсан тохиолдолд таны өгөх санал | Гарын үсэг |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох | ☐ | ☐ | ☐ | | |

Саналын хуудас хүлээн авсан: Брокер ..............................................
/ Гарын үсэг, тэмдэг/

2020 оны ...... сарын ......

Саналын хуудсыг **хүчинтэйд** тооцсон тооллогын комиссын дарга: ........................ /Б.Онон/
/ Гарын үсэг/
Саналын хуудсыг **хүчингүйд** тооцсон шалтгаан:
..............................................................................................................................
..............................................................................................................................
..............................................................................................................................

АПУ ХК –ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2020 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн
20/15 тоот тогтоолын хоёрдугаар хавсралт

**АПУ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТААР ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС**

**Хэлэлцэх асуудал №2**

Хувьцаа эзэмшигчийн овог: .............................. Нэр: ........................................
Регистрийн дугаар: ..........................................
Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн Тоо: ........................................
Кумулятив саналын тоо: ..................................
Бүртгэсэн /Үнэт цаасны компани/: ...........................................................................
Брокерийн овог: ................................... Нэр: ........................................

Энэхүү саналын хуудсаар 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 16:00 цаг хүртэл БиДиСек ҮЦК ХК-ийн байр (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө, 27/1 тоот) болон санал өгөгчийн харилцагч үнэт цаасны компанийн байранд санал өгнө.

**Дараах хэлэлцэх асуудалд КУМУЛЯТИВ АРГААР санал хураана.**
**Саналын хуудас бөглөх заавар:** АПУ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь ердийн 6 гишүүн, хараат бус 3 гишүүнтэй байна. Кумулятив саналын тоо нь таны эзэмшиж байгаа энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна.
Жишээ нь: Та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл нийт 100*9=900 кумулятив саналын эрхтэй болно. Үүнээс ердийн гишүүн 6 байх тул 100*6=600 кумулятив саналын эрхээ ердийн гишүүнд нэр дэвшиж буй 6 хүртэлх нэр дэвшигчид, хараат бус гишүүнд 3 гишүүн байх тул 100*3=300 кумулятив саналын эрхээ хараат бус гишүүнд нэр дэвшиж байгаа 3 хүртэлх нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй.

| 2 | **ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:**<br>АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд (кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн)-ийг сонгох | |
|---|---|---|
| | ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД | **Нэр дэвшигчид өгөх саналын тоо** |
| 1 | П.Батсайхан | |
| 2 | Б.Батбаяр | |
| 3 | Сергей Громов | |
| 4 | Кеннет Чу | |
| 5 | Сэн И-Ин | |
| 6 | Томас Холланд | |
| | ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД | **Нэр дэвшигчид өгөх саналын тоо** |
| 7 | Ө.Батбаяр | |
| 8 | Е.Гэрэлчулуун | |
| 9 | Ж.Үнэнбат | |

Санал өгсөн хувьцаа эзэмшигч: .............................................
/ Гарын үсэг/

Саналын хуудас хүлээн авсан: Брокер .............................................
/ Гарын үсэг, тэмдэг/

2020 оны ...... сарын ......

Саналын хуудсыг **хүчинтэй**д тооцсон тооллогын комиссын дарга: ........................ /Б.Онон/
/ Гарын үсэг/
Саналын хуудсыг **хүчингүй**д тооцсон шалтгаан:
.............................................................................................................................
.............................................................................................................................

## САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Эчнээ санал хураалтад оролцож санал өгөх хувьцаа эзэмшигч та 2020 оны 09 сарын 02-ны бүртгэлийн өдрөөр эзэмшиж буй хувьцааны тоогоор санал өгнө. Иймд бүртгэлийн өдрөөс өмнө санал өгсөн хувьцаа эзэмшигчийн хувьцааны тоонд бүртгэлийн өдөр хүртэл өөрчлөлт орсон бол тухайн санал хүчингүй болж, дахин санал өгөхийг анхаарна уу.
2. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
3. Итгэмжлэлээр санал өгч буй итгэмжлэгдсэн төлөөлөгч нь итгэмжлэл дээрх өөрийн баталгаат гарын үсгийг зурснаар санал хүчинтэйд тооцогдоно.
4. Насанд хүрээгүй хувьцаа эзэмшигчийн асран хамгаалагч нь хүүхдийнхээ бус өөрийнхөө гарын үсгийг зурснаар санал хүчинтэйд тооцогдоно.
5. **Ердийн аргаар** өгөх санал хураалтад хэлэлцэх асуудал тус бүр дээр нэгээс олон тэмдэглэгээ хийсэн болон гарын үсгээ зураагүй тохиодолд саналын хуудсыг хүчингүйд тооцно.
6. **Кумулятив аргаар** ТУЗ-д нэр дэвшигчдэд өгсөн нийт саналын тоо кумулятив саналын тооноос зөрсөн болон гарын үсэггүй тохиолдолд саналын хуудсыг хүчингүйд тооцно.